

“ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 05-р сарын 16-ны өдөр

№ 23/01

Улаанбаатар хот

Монголын Хөрөнгийн Биржийн III ангилалд бүртгэлтэй Люкс Занаду Групп хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 15 цагт эхэлж ТУЗ-ийн гишүүд, компанийн гүйцэтгэх захирал, Тооллогын комиссын гишүүд Шангри-Ла оффис-н 801 тоотод, Хувьцаа эзэмшигчид Зүүм /ZOOM/ платформоор дамжуулан хуралд оролцов.

Хурал зохион байгуулах комисс хурлыг холбогдох журамын дагуу зохион байгуулсан ба тооллогын комисс хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийг холбогдох журмын дагуу бүртгэн авч нийт ирцийг танилцуулав. Хувьцаа эзэмшигчдийн энэ удаагийн ээлжит хуралд 75,000 ширхэг энгийн хувьцаа эзэмшдэг 2 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар оролцож байгаа нь нийт саналын эрх бүхий 82,871 ширхэг энгийн хувьцааны 90.5% болж байгааг хуралд оролцогч болон хурлын даргад мэдээлэв. Тооллогын комисс хурлын ирцийг танилцуулж, хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай комиссын тогтоолыг уншиж танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга Баянмөнхийн Сугарсүрэн хурлыг нээж хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдэд талархал илэрхийлэв. Мөн тэрээр хурлын дэг болон хэлэлцэх дараах асуудлуудыг танилцуулав. Хэлэлцэх асуудлуудад:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэх;
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинэчлэн сонгох;
3. Компанийн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны болон бусад төсөл төлөвлөгөөг тайлагнах;
4. Ногдол ашиг хуваарилахгүй тухай тайлагнах;
5. Бусад;

Хурлын дарга хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдэд эхний хэлэлцэх асуудалдаа орохоос өмнө хэлэлцэх асуудал болон хурлын дэгтэй холбоотой асууж тодруулах зүйлс байгаа эсэхийг асуув.

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс тодруулах зүйлс гараагүй тул хурлыг эхлүүлэв.

Компанийн гүйцэтгэх захирал Сугарсүрэн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг уншиж танилцуулав.

Сугарсүрэн: “Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс өгсөн дүгнэлттэй холбоотойгоор хувьцаа эзэмшигчдээс асуулт байна уу?”

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс оор асуух зүйлс гараагүй тул дараагийн хэлэлцэх асуудалдаа оров.

Хурлаар хэлэлцэх дараагийн асуудал болох “Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинэчлэн сонгох” талаар хурлын дарга танилцуулав. ТУЗ-н гишүүдийг улираан сонгож байгаа учир нэмэлт танилцуулга хийх шаардлагагүй гэж үзэж байна.

ТУЗ-ийн ердийн гишүүнд:

1. Бямбажавын Насан-Эрдэнэ
2. Аюурзанын Хадбаатар
3. Эрдэнэбатын Болор-Эрдэнэ
4. Сэрдамбын Отгонбилэг
5. Батхүрэлийн Одмаа
6. Баянмөнхийн Сугарсүрэн

ТУЗ-ийн хараат бус гишүүнд:

1. Баяраагийн Пүрэвжаргал
2. Болдбаатарын Болорцэцэг
3. Отгонжаргалын Нандинчимэг

Хурлын дарга Сугарсүрэн: “ТУЗ-ийн гишүүдийн санал хураалтын кумулятив аргаар сонгон шалгаруулдагийг та бүрэн мэдэж байгаа байх. Үүнийг анхаарч та бүхнийг саналаа өгсөн гэж найдаж байна. Хэлэлцэх асуудлуудаа дуусгачихаад санал хураалтын үр дүнгээ танилцуулах болно”

Дараагийн хэлэлцэх асуудал болох “Компанийн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны болон бусад төсөл төлөвлөгөөг батлах” талаар хурал үргэлжлэв.

Хурлын дарга бөгөөд гүйцэтгэх захирал Сугарсүрэн: “Өмнө нь та бүхэнд танилцуулсан уул уурхайн бус экспортын компаниудыг нэгтгэх ажлууд төлөвлөсний дагуу амжилттай хэрэгжвэл бид Монгол улсын эдийн засгийг төрөлжүүлэх үйлсийн томоохон төлөөлөгч болох нь тодорхой. Хувьцаа эзэмшигчдэд хүргүүлсэн хурлын материалтай та бүхэн бүрэн танилцсан бол цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлуудын талаар мэдээлтэй болсон гэж бодож байна. Бид эхний ээлжинд хушны самар болон махны экспортыг өргөжүүлж ажиллахаар төлөвлөж байгаа бөгөөд цаашид бусад таваарын бүтээгдэхүүнийг экспортлох ажлаа ч ирэх онд эхлүүлнэ”

Уг асуудалтай холбоотой тодруулах зүйлс байгаа эсэхийг хувьцаа эзэмшигчдээс асуухад асууж тодруулах зүйлс гараагүй тул хурлын дараагийн асуудалд шилжив.

Сугарсүрэн: “Хурлаар хэлэлцэх дараагийн асуудалдаа ороё. Дараагийн асуудал Ногдол ашиг хуваарилахгүй тухай тайлагнах юм.

Компанийн санхүүгийн нөхцөл байдлаас шалтгаалан 2022 онд алдагдалтай ажилласан тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн. Ирэх жилээс бидний эхлүүлсэн ажлын үр дүн гарч, түүнчлэн эдийн засгийн нөхцөл байдал сэргэнэ гэж найдаж байгаа ба ашигтай ажиллана гэж төлөвлөж байна. Хэрэв бид дараа жилээс ашигтай ажиллаж эхлэвэл ногдол ашиг тараах эсэх шийдвэрээ эргэн харах болно”

Хурлын дарга Сугарсүрэн хэлэлцэх үндсэн асуудлууд үүгээр дуусч байгааг хуралд оролцогч нарт мэдээлж хурлын дэгийн дагуу санал хураалтын үр дүнг танилцуулах болсон талаар хэлэв.

Тооллогын комиссын Дарга Үүрийнтуяа Хувьцаа эзэмшигчдийн хурлын үеэр хэлэлцсэн асуудлуудын санал хураалтын үр дүнг хурлын дэгийн дагуу танилцуулав. Үүнд:

- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгохдоо кумулятив аргыг ашигласан ба ердийн гишүүнээр:

1. А.Хадбаатар
2. Б.Сугарсүрэн
3. Б.Насан-Эрдэнэ
4. Б.Одмаа
5. Э.Болор-Эрдэнэ
6. С.Отгонбилэг

1. Б.Пүрэвжаргал
2. Б.Болорцэцэг
3. О.Нандинчимэг нарыг сонголоо.

- Тооллогын комиссын дарга тооллогын үр дүнг танилцуулж дууссаны дараа Хурлын дарга хурлаас гарсан Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол шийдвэрийг уншиж танилцуулсан юм.

Үнийн дараа Хурлын дарга Сугарсүрэн хурлыг хааж үг хэлснээр хурал өндөрлөв.

Хурал: 17:00 цагт өндөрлөв.

Тэмдэглэл хөтөлсөн: *Б.Пүрэвжаргал* /Б.Пүрэвжаргал/



